



“ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР
49173-003-МОН

ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ
ХӨГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн барилгын үйл ажиллагааны ТӨЛӨВЛӨЛТ

ЭМАШТҮ-ний Хөгжлийн Зөвлөх Баг

Хувилбар-03

2022.04.27

2022 оны 4 дүгээр сар

Агуулга

| | |
|--|----|
| 1. ТАНИЛЦУУЛГА | 4 |
| 1.1. Монгол улсын эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний эрх зүйн орчин..... | 4 |
| 1.2. Төсөлд тусгасан үйл ажиллагааны төлөвлөлтийн ерөнхий загвар..... | 6 |
| 1.3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хөгжлийн зөвлөх баг..... | 6 |
| 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ | 7 |
| 2.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний төрлүүдийн талаарх нэгдсэн ойлголт | 7 |
| 2.2 Эрүүл мэндийн анхан шатанд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний тодорхойлолт8 | |
| 2.3 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний гол зарчмууд..... | 9 |
| 2.4 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний зохион байгуулалтанд анхаарах асуудлууд..... | 13 |
| 2.5 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэл | 14 |
| 2.5.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ | 14 |
| 2.5.2 Өдрийн эмчилгээ | 15 |
| 2.5.3 Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ | 16 |
| 2.5.4 Лаборатори | 17 |
| 2.6 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт | 18 |
| 3. СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ | 19 |
| 3.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын үйл ажиллагааны төлөвлөгөө | 20 |
| 3.1.1. Загвар өрхийн эрүүл мэндийн төв..... | 22 |
| 3.2 Сумын эрүүл мэндийн төвийн барилгын үйл ажиллагааны төлөвлөгөө | 26 |
| 3.2.1. Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төв..... | 27 |
| 3.2.2 Булган аймгийн Дашинчилэн сумын эрүүл мэндийн төв | 32 |
| 3.2.3 Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв..... | 39 |
| 3.2.4 Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төв | 43 |

Товчилсон үгс

| | |
|--------|---|
| АХБ | Азийн Хөгжлийн Банк |
| ДЭМБ | Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага |
| ИЭМЦБ | Иргэний Эрүүл Мэндийн Цахим Бүртгэл |
| ӨЭМТ | Өрхийн Эрүүл Мэндийн Төв |
| ОХБ | Оношийн Хамааралтай Бүлэг |
| МЭЗЭМ | Макро Эдийн Засаг ба Эрүүл Мэнд |
| НЭМГ | Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар |
| СЭМТ | Сумын Эрүүл Мэндийн Төв |
| ТББ | Төрийн Бус Байгууллага |
| ТЭМТ | Тосгоны Эрүүл Мэндийн Төв |
| ТХН | Төсөл Хэрэгжүүлэх Нэгж |
| ТХХТ | Төр, Хувийн Хэвшлийн Түншлэл |
| ТУХ | Төслийн Удирдах Хороо |
| ТТ | Техникийн Туслалцаа |
| ТАХ | Техникийн Ажлын Хэсэг |
| ЭМАШТҮ | Эрүүл Мэндийн Анхан Шатны Тусламж Үйлчилгээ |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМДЕГ | Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМДС | Эрүүл Мэндийн Даатгалын Сан |
| ЭМДҮЗ | Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөл |
| ЭМСХХ | Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр |

1. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү “Өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны төлөвлөлт”-ийг барилгын зураг зурахаар сонгон шалгарсан байгууллагад зориулан “Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөгжил”-ийн зөвлөх багаас боловсруулан гаргаж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээлийн 49173-003-МОН “Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөтөлбөр” төслийн хүрээнд санхүүжилтын 1 дүгээр үе шат (2020-2025)-анд зорилтот бүлгийн хүн амд эрүүл мэндийн өргөтгөсөн үйлчилгээ үзүүлэх жөндөрийн болон үйлчлүүлэгчдэд ээлтэй 3 өрхийн эрүүл мэндийн ЗАГВАР төв, 4 сумын эрүүл мэндийн ЗАГВАР төвүүдийг тус тус шинээр байгуулна. Үүнд:

1. Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв
2. Чингэлтэй дүүргийн 19 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв
3. БЗД-ийн 17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв
4. Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төв
5. Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төв
6. Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв
7. Булган аймгийн Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв

Энэхүү төлөвлөгөөг 2022 оны 5-6 дугаар сард боловсруулахаар төлөвлөсөн боловч, төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) болон төслийн захирлын өгсөн үүргийн дагуу 2022 оны 3-4 дүгээр сард боловсруулсан.

1.1. Монгол улсын эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний эрх зүйн орчин

Өнөөдөр Монгол улсын эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, гарц үр дүнд суурилсан, бодлого төлөвлөлттэй уялдуулсан төсвийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, стратегийн худалдан авалт хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг шинэчлэн тооцох, хөрөнгө оруулалт, эмнэлгийн хүний нөөцийн ачаалал, бодлого төлөвлөлт, үр дүнг санхүүжилттэй уялдуулж авч үзэх нөхцлийг бүрдүүлсэн тогтолцооны суурийг тавьж байна.

2020 оны 5 дугаар сард Монгол Улсын Их Хурал нь Эрүүл Мэндийн тухай Хуулийг шинэчилсэн бөгөөд үүнд “3.1.24."эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ" гэж хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх үйл ажиллагааг;” гэж тодорхойлсон.

2016 оны 4 дүгээр сард дээрх хуулийг шинэчилсэн бөгөөд үүнд “13.5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь анхан болон лавлагаа шатлалтай байна...”, мөн “15.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага дараах төрөлтэй байна:

15.1.1.өрхийн эрүүл мэндийн төв;

15.1.2.сум, тосгоны эрүүл мэндийн төв;...” гэж тус тус заасан байна.

Эрүүл мэндийн тухай хууль(2016)-д ӨЭМТ-ийн чиг үүргийг “16.2.Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.” гэж заасан.

Сумын эрүүл мэндийн төв (СЭМТ)-ын үйл ажиллагаатай холбоотой дараах стандарт, тушаал шийдвэрүүд байна. Үүнд:

- 2013 оны (үндэсний стандарт MNS 5081:2013) Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт,
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/52 тоот тушаалаар батлагдсан “Сум, тосгоны ЭМТ-д тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, тусламж үйлчилгээний жагсаалт,
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/256 тоот тушаалаар батлагдсан “Журам батлах тухай” (Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх).

Өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ)-ын үйл ажиллагаатай холбоотой дараах тушаал шийдвэрүүд байна. Үүнд:

- 2017 оны (үндэсний стандарт MNS 5292:2017) стандартаар батлагдсан “ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”,
- Эрүүл мэндийн сайдын тушаал 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/212 тоот тушаалар батлагдсан “ӨЭМТ-ийн үлгэрчилсэн дүрэм”,

- Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/216 тоот тушаалаар батлагдсан “ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээний багц”,

Эдгээр одоогоор хүчинтэй мөрдөгдөж байгаа тушаал, шийдвэр, стандартыг энэхүү төлөвлөгөөг боловсруулахад ашигласан болно.

1.2. Төсөлд тусгасан үйл ажиллагааны төлөвлөлтийн ерөнхий загвар

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ:

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ,
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны төлөвлөлт.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг Зөвлөх Багийн хийсэн “Монгол улсын эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний түргэвчилсэн үнэлгээ”, нотолгоонд суурилсан, хүн ам зүй, тархвар судлалын мэдээлэл, “Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн “2020 оны эрүүл мэндийн үзүүлэлт”, холбогдох хууль, стандарт, сайдын тушаал шийдвэрүүдийг үндэслэж боловсруулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах чиглэлээр дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан болно:

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний төлөвлөлтийн тодорхойлолт,
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны төлөвлөлт,
- Талбайн төлөвлөлт (талбайн төлөвлөлт, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хэсэг, нэгжийн хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, талбайн ашиглалт зэргийн хамт).

1.3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хөгжлийн зөвлөх баг

Энэхүү төлөвлөгөөг дараах бүрэлдэхүүнтэй зөвлөх баг боловсруулсан болно:

Найжел МакКарли (Багийн ахлагч, GOPA Worldwide)

С. Сонин (Багийн дэд ахлагч, Монконсалт)

П. Алтанхуяг (ЭМАШТУ-ий Чанарын удирдлагын мэргэжилтэн, Монконсалт)

Д.Чимэддагва (ЭМАШТУ-ий Санхүүжилт хариуцсан мэргэжилтэн, Макроэдийн засаг ба Эрүүл мэнд ТББ)

2. ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

2.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний төрлүүдийн талаарх нэгдсэн ойлголт

2016 оны 4 дүгээр сард өөрчлөн найруулсан “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн “13.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дараах төрөлтэй байна:

13.1.1.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

13.1.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээ....”, гэж заасан.

2020 оны 8 дугаар сард өөрчлөн найруулсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийн “4.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ дараахь төрөлтэй байна:

4.1.1.өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний анхан шатны тусламж, үйлчилгээг бие дааж, эсхүл багаар үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

4.1.2.өрхийн анагаах ухаанаас бусад мэргэшлийн эмнэлгийн мэргэжилтний бие дааж, эсхүл багаар үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;

4.1.3.жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;

4.1.4.хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;

4.1.5.гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

4.1.6.өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжих, хөнгөвчлөх, илааршуулахад чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;

4.1.7.өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ....” гэж тус тус тодорхойлсон.

Мөн энэхүү хуулийн "6.1.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь... дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.4 ... сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх;

6.1.5.сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх..." гэж тус тус заасан байна.

Эдгээр хуулийн заалтуудыг үндэслэн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний төрлүүдийг тодорхойлж, энэхүү төлөвлөгөөнд тусгасан.

2.2 Эрүүл мэндийн анхан шатанд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний тодорхойлолт

Зөвлөх багийнхан:

1. Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв
2. Чингэлтэй дүүргийн 19 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв
3. БЗД-ийн 17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв
4. Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төв
5. Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв
6. Булган аймгийн Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв тус

бүрийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, байгууллагын статистик мэдээллийг цуглуулж, холбогдох баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр энэхүү төлөвлөгөөг боловсруулсан.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А52 тоот тушаалаар баталснаар СЭМТ-д дараах эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Жирэмсэн, төрсний дараах үеийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
- Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Дархлаажуулалтын тусламж, үйлчилгээ
- Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээ
- Халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээ

- Сувилахуйн тусламж, үйлчилгээ.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А129 тоот тушаалаар баталснаар ӨЭМТ-д дараах үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээ
- Халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээ
- Яаралтай үеийн тусламж, үйлчилгээ.
- Сувилахуйн тусламж, үйлчилгээ.
- Амбулаторийн тусламж, үйлчилгээ
- Цахилгаан эмчилгээ
- Хөдөлгөөн эмчилгээ
- Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Өдрийн эмчилгээ
- Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ
- Оношилгоо, лабораторийн үйлчилгээ

2.3 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний гол зарчмууд

Үйлчлүүлэгчийг эмнэлэг хооронд шилжүүлэх, хэвтэн эмчлүүлэхээс гадна өдрийн болон амбулаторын үйлчилгээг илүү оновчтой ашигласан, өвчтөнд ээлтэй сум, өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ ЗАГВАР-ыг бий болгож, үйлчлэх хүрээний хүн амд өндөр үр ашиг буюу бүтээмжтэй, үр нөлөөтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Одоо мөрдөж байгаа “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа”-ны стандартаар “6.10.1 Орны тоо нь сум, тосгоны эрүүл мэндийн төвийн зэрэглэлээс хамааран харилцан адилгүй байна.

6.10.1.1 Нэгдүгээр зэрэглэлийн сум, тосгоны эрүүл мэндийн төв нь нийт 5-7 хүртэл ортой, үүнээс цочмог өвчин болон ажиглалтад зориулсан 1-2 ор, төрөхийн 1 ортой байна;

6.10.1.2 Хоёрдугаар зэрэглэлийн сум, тосгоны эрүүл мэндийн төв нь нийт 7-11 хүртэл ортой, үүнээс цочмог өвчин болон ажиглалтад зориулсан 2-4 ор, төрөхийн 1-2 ортой байна.

6.10.1.3 Гуравдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь нийт 15-20 хүртэл ортой, үүнээс цочмог өвчин болон ажиглалтад зориулсан 3-4 ор, төрөхийн 2 ортой байна” гэсэн заалтыг эмнэлгийн орны төлөвлөлтөнд ашигласан.

Хүснэгт 1. СЭМТ-д хэвтүүлэн эмчлэх хүний тоо, шаардлагатай эмнэлгийн орны тооцоо

| Үзүүлэлтүүд | | Хөвсгөл Тариалан "А" зэрэглэл | Дорноговь Эрдэнэ "А" зэрэглэл | Булган Дашинчилэн "Б" зэрэглэл | Өвөрхангай Баян-Өндөр "Б" зэрэглэл |
|-------------------------------------|--|-------------------------------------|-------------------------------------|--------------------------------------|--|
| СЭМТ-ийн статистикийн үзүүлэлтүүд | Хүн амын тоо (2023 оны таамаглал) | 6,694 | 2,456 | 3,158 | 3,744 |
| | Орны фонд ашиглалт (сүүлийн 5 жилийн дундаж, хувиар) | 72.6 | 70.6 | 53.9 | 35.0 |
| | Орны фонд ашиглалт (сүүлийн 5 жилийн дундаж, хоногоор) | 240 | 233 | 178 | 116 |
| | Жилийн дундаж орны тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 22 | 8 | 10 | 15 |
| | Дундаж ор хоног (сүүлийн 5 жилийн дундаж) | 7.1 | 6.9 | 7.0 | 6.4 |
| | Эмчилсэн өвчтөний тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 741 | 269 | 254 | 270 |
| | Нийт ашигласан ор хоног (сүүлийн 5 жилийн дундаж) | 5,274 | 1,864 | 1,778 | 1,733 |
| Орны фонд ашиглалт (таамаглал) % | 70.0 | 70.0 | 70.0 | 70.0 | |
| Дундаж ор хоног (таамаглал) | 7.2 | 7.0 | 7.1 | 6.5 | |
| Ор ашиглах жилийн дундаж хоног | 256 | 256 | 256 | 256 | |
| Төлөвлөсөн нийт ор хоног | 5,621 | 2,811 | 2,811 | 3,066 | |
| Жилд хэвтүүлэн эмчлэх хүний тоо | 781 | 402 | 396 | 472 | |
| 10,000 хүн амд ноогдох орны тоо | 33 | 45 | 35 | 32 | |
| Эмнэлгийн орны нийт тоо | 22 | 11 | 11 | 12 | |
| Үүнээс | Дотрын | 10 | 4 | 4 | 4 |
| | Хүүхдийн | 5 | 3 | 3 | 3 |
| | Төрөх | 2 | 1 | 1 | 1 |
| | Халдварт | 1 | 1 | 1 | 1 |
| | Тусгаарлах | 1 | 1 | 1 | 1 |
| | Цочмог өвчин ажиглалтын ор | 2 | 1 | 1 | 1 |
| | Эрчимт эмчилгээ | 1 | 0 | 0 | 1 |

Хүснэгт 2. СЭМТ-ийн амбулаторын үзлэгийн тооцоо

| Үзүүлэлт | | Хөвсгөл Тариалан "А" зэрэглэл | Дорноговь Эрдэнэ "А" зэрэглэл | Булган Дашинчилэн "Б" зэрэглэл | Өвөрхангай Баян-Өндөр "Б" зэрэглэл |
|---|---|--|--|--------------------------------------|--|
| СЭМТ-ийн статисти- кийн үзүүлэлтүүд | Амбулаторийн нийт үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 23,858 | 11,048 | 7,149 | 2,939 |
| | Өвчний учир амбулаторийн үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 2,582 | 2,681 | 2,156 | 1,431 |
| | Амбулаторийн анхны үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 402 | 1,406 | 500 | 756 |
| | Амбулаторийн давтан үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 2,180 | 1,275 | 1,656 | 675 |
| Өдөрт 1 эмчийн үзэх хүний тоо | 16 | 16 | 16 | 16 | |
| Амбулаторийн үзлэгийн эмчийн тоо (хэрэгцээ) | 6 | 4 | 3 | 2 | |
| Жилд үзлэг хийх өдрийн тоо | 240 | 240 | 240 | 240 | |
| Төлөвлөж байгаа жилийн үзлэгийн тоо | 23,040 | 15,360 | 11,520 | 7,680 | |

Хүснэгт 3. СЭМТ-ийн хүний нөөцийн тооцоо

| Үзүүлэлт | Хөвсгөл Тариалан "А" зэрэглэл | Дорноговь Эрдэнэ "А" зэрэглэл | Булган Дашинчилэн "Б" зэрэглэл | Өвөрхангай Баян-Өндөр "Б" зэрэглэл |
|--|--|--|--------------------------------------|--|
| Хүн амын тоо (2021 оны байдлаар) | 6,422 | 2,440 | 3,102 | 3,734 |
| Жилд нэмэгдэх хүний тоо (сүүлийн 4 жилийн дундажаар) | 136 | 8 | 28 | 5 |
| Хүн амын тоо (2023 оны таамаглал) | 6,694 | 2,456 | 3,158 | 3,744 |
| 10,000 хүн амд ноогдох их эмчийн тоо | 7.5 | 16.3 | 12.7 | 10.7 |

| | | | | | |
|--|---|------|------|------|------|
| 10,000 хүн амд ноогдох сувилагчийн тоо | | 14.9 | 32.6 | 25.3 | 18.7 |
| Сувилагч, эмчийн харьцаа | | 2.0 | 2.0 | 2.0 | 1.8 |
| Нийт ажиллагсдын тоо (төлөвлөлт) | | 33 | 28 | 27 | 27 |
| Нийт их эмч | | 5 | 4 | 4 | 4 |
| Үүнээс | Ерөнхий мэргэжлийн | 1 | 1 | 1 | 1 |
| | Дотрын эмч | 1 | 1 | 1 | 1 |
| | Хүүхдийн эмч | 1 | 1 | 1 | 1 |
| | Эмэгтэйчүүдийн эмч | 1 | | | |
| | Шүдний эмч | 1 | | | |
| | Уламжлалтын эмч | | 1 | 1 | 1 |
| Нийт сувилагч | | 10 | 8 | 8 | 7 |
| Үүнээс | Ээлжийн сувилагч | 4 | 4 | 4 | 4 |
| | Ахлах сувилагч | 1 | | | |
| | Өдрийн эмчилгээний сувилагч | 1 | 1 | 1 | 1 |
| | Дархлаажуулалтын сувилагч | 1 | 1 | 1 | 1 |
| | Сэргээн засах, физик эмчилгээний сувилагч | 1 | 1 | 1 | 1 |
| | Мэс заслын сувилагч | 1 | 1 | 1 | |
| | Шүдний сувилагч | 1 | | | |
| Бусад эмнэлгийн дунд мэргэжилтэн | | 12 | 10 | 9 | 10 |
| Үүнээс | Эх баригч | 2 | 1 | 1 | 1 |
| | Лаборант | 1 | 1 | 1 | 1 |
| | Статистикч бага эмч | 1 | 1 | 1 | 1 |
| | Ариутгагч | 1 | 1 | 1 | 1 |
| | Багийн бага эмч | 5 | 4 | 3 | 4 |
| | Нийгмийн ЭМ-ийн ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| | Мэдээллийн ажилтан/хөтөч | 1 | 1 | 1 | 1 |
| Бусад ажилтнууд | | 6 | 6 | 6 | 6 |
| Үүнээс | Тогооч | 1 | 1 | 1 | 1 |
| | Нягтлан бодогч | 1 | 1 | 1 | 1 |
| | Нярав | 1 | 1 | 1 | 1 |
| | Бусад | 2 | 2 | 2 | 2 |
| | Жолооч | 1 | 1 | 1 | 1 |

Хүснэгт 4. ӨЭМТ-ийн амбулаторын үзлэгийн тооцоо

| Үзүүлэлтүүд | | Баянзүрх 17-р хороо "Орхон түшээ мөрөн" | Чингэлтэй 19-р хороо "Ундрах ирээдүй" | Хан-Уул 10-р хороо "Амин тус" |
|--|---|---|---------------------------------------|-------------------------------|
| статисти- | Амбулаторийн нийт үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 18,057 | 41,146 | 26,293 |
| | Өвчний учир амбулаторийн үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 1217 | 10057 | 4551 |
| ӨЭМТ-ийн кийн үзүүлэлтүүд | Амбулаторийн анхны үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 377 | 2399 | 1572 |
| | Амбулаторийн давтан үзлэгийн тоо (сүүлийн 5 жилийн дундаж) | 840 | 7658 | 2979 |
| | Хүн амын тоо | 9,824 | 10,765 | 15,595 |
| Өдөрт 1 эмчийн үзэх хүний тоо | | 16 | 16 | 16 |
| Үзлэгийн эмчийн тоо | | 6 | 6 | 7 |
| Жилд үзлэг хийх өдрийн тоо | | 240 | 240 | 240 |
| Төлөвлөж байгаа жилийн нийт үзлэгийн тоо | | 23,040 | 23,040 | 26,880 |

2.4 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний зохион байгуулалтанд анхаарах асуудлууд

Долоо хоногийн эхний 2 өдөр үдээс өмнө эмнэлэгт үзүүлэхээр хэт их ачаалал үүсч байгаа тул, утсаар болон цахимаар үзлэгийн цаг товлох тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

СЭМТ-д их эмч дутагдалтай байна. Тухайлбал Дорноговь аймгийн Эрдэнэ суманд зун хэт халуун, өвөл хүйтэн, хавар шороо их тавьдаг, байгаль цаг уурын бэрхшээлээс болж, ирсэн их эмч нар 1 жилээс хэтрэлгүй буцдаг тул, сумын иргэдийн хурлаас шийдвэр гаргаж статистикч бага эмчийг СЭМТ-ийн даргаар ажиллуулдаг байна. Иймд

цаашид зөвлөх багийн зүгээс эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар хүний нөөцийн туршилтын загвар хэрэгжүүлэх болно.

Өвөрхангай аймгийн Баян-Өндөр СЭМТ-ийн орны фонд ашиглалт маш бага байгаа тул цаашид эмнэлгийн орны тоог бууруулж тооцсон болно.

Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Дашинчилэн сумдын төвөөр баруун чиглэлийн төв автозам дайрч байгаа, мөн Дорноговь аймгийн Эрдэнэ төвийг төмөр зам дайрдаг, урд чиглэлийн автозам 18 км-ын зайтай өнгөрдөг тул, осол гэмтэл, явуулын хүмүүс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нилээд их авдаг тул, жижиг мэс ажилбар хийх болон, цэвэр бохир боолтын өрөөтэй байхаар төлөвлөсөн болно.

2.5 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэл

2.5.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ

Үүрэг, үйл ажиллагаа: Амбулаторийн тусламж, үйлчилгээ нь амбулаториор ирж байгаа үйлчлүүлэгчдийг оношилж, эмчлэх зорилготой. Энд ихэвчлэн онош тодруулж, эмнэлгийн зөвлөгөө өгнө. Амбулаториор лабораторийн шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг гэх мэт оношилгоо, шинжилгээнүүдийг хийнэ. Амбулаторийн хэсэг нь ирж буй үйлчлүүлэгчдэд хаалга баригчийн үүрэг гүйцэтгэж, хэвтүүлэн эмчлэх, лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. Амбулаторийн үзлэгийн эмч нар өөрийн байгууллагын боломж нөхцлийн хүрээнд үйлчлүүлэгчдийг аль болох эмчлэхийг хичээх ёстой. Үүнд үзлэг, зөвлөгөө, сувилахуйн ажилбар, лабораторийн шинжилгээ бүгд хамаарагдана. Шаардлагатай бол өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх, дээд шатлалын эмнэлэгт шилжүүлж болно.

Хүний нөөцийн бодлого: Эмч үйлчлүүлэгчид тохирох тусламж үйлчилгээг тасралтгүй хангахын тулд тухайн хүний тусламж авч буй бүхий л байрлал, нөхцөлд ажиллана. Жишээ нь амбулаторийн А гэдэг эмч даваа гарагт үзлэгт ирсэн үйлчлүүлэгч Б-г хэвтэн эмчлүүлэхийг зөвлөжээ. Тухайн эмч мягмар гарагт үйлчлүүлэгч Б-г тасагт үзээд лхагва гарагт эмийн эмчилгээ хийжээ. Өвчтөн Б эмнэлгээс гарсаны дараа тухайн амбулаторт Б гэдэг эмчийн хяналтанд орно. Өөрөөр хэлбэл тухайн үйлчлүүлэгчийг бүрэн эдгэртэл нэг эмч бүрэн хариуцаж оношилж, эмчилнэ гэсэн үг юм. Мөн сувилагч нар

амбулаторийн эмчийн шинжилгээ, оношилгоо хийх (ЭКГ, цусны дээж авах), амин үзүүлэлтүүдийг хянах зэрэг үйл ажиллагаанд дэмжин оролцоно.

Стратегийн асуудлууд: Бид СЭМТ-д сувилагчийн үзлэг хийж зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгохыг зөвлөж байна. Сувилагч нар урт хугацааны эмчилгээ шаардлагатай өвчтөнийг эмчлэх бөгөөд голчлон халдварт бус өвчтөнийг хянах, амьдралын зөв дадал ба эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хариуцан явуулна. Мөн түүнчлэн архаг шархны эмчилгээ, мэс заслын дараах тусламж, хяналтыг (цусны даралт, цусан дахь чихрийн хэмжээ г.м) хийх юм. Үүний тулд одоогийн манай сувилагч нарт илүү өргөн хүрээнд бие даан ажиллах шаардлага тулгарах болно.

Үйл ажиллагааны төсөөлөл: Амбулаторийн үйлчилгээ ажлын өдрүүдэд хамгийн багадаа 08:00-17:00 цагийн хооронд явагдана. Эмч нар ээлжээр 1-2 долоо хоног тутамд нэг удаа оройн үзлэг хийж үзлэгийн цагийг 8:00-20:00 болгон нэмэгдүүлж ажил эрхэлж буй хүн амын эмнэлэгт хандалтыг нэмэгдүүлэх боломжтой.

2.5.2 Өдрийн эмчилгээ

Үүрэг, үйл ажиллагаа: Энд эмнэлэгт хонож эмчилгээ хийлгэхгүй үйлчлүүлэгчдэд өдрийн эмчилгээ хийнэ. Өдрийн эмчилгээг ихэвчлэн амбулаторийн үйлчлүүлэгчдэд хийх боловч зарим үед хэвтэн эмчлүүлэгчдийг эмнэлгээс гарсны дараах хяналт тавьж эмчилгээг үргэлжлүүлэн хийж болно.

Өдрийн эмчилгээний хэсэгт жижиг мэс ажилбар, шүдний эмчилгээ болон судас тариа, эмнэлэгт хэвтэхгүй боловч ойр ойрхон хяналт хийх шаардлагатай богино хугацааны эмчилгээнүүд (жишээ нь хавдрын эмчилгээ) хийхэд тохиромжтой.

Хүний нөөцийн бодлого: Өдрийн эмчилгээг дээр дурьдсанаар эмнэлгийн янз бүрийн хэсэгт (Амбулатори, стационар, яаралтай тусламжийн хэсэг г.м) эмч, сувилагч нар гүйцэтгэх юм. Үйлчлүүлэгчийн эмчилгээг тасралтгүй явуулахын тулд бүтэн эмчилгээний туршид нэг сувилагч хариуцан ажиллах нь оновчтой. Сувилагч, туслах сувилагч нар үйлчлүүлэгчийг мэс ажилбар, эмчилгээнд бэлтгэх, эмчид туслах, үйлчлүүлэгчийг хүлээн авах үүрэгтэй.

Стратегийн асуудлууд: Шаардлагагүй олон хэвтэн эмчлүүлж буй тохиолдлуудад өдрийн эмчилгээг санал болгох нь зүйтэй. Үйлчлүүлэгч эмнэлэгт хонохгүй учир

өвчтөний ажлын болон хувийн амьдралд үзүүлэх нөлөө багатай, маш үр дүнтэй үйлчилгээ юм. Одоогийн шинэ эрүүл мэндийн даатгалын хуулиар өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байна. Үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэхээс өмнө өдрийн эмчилгээ хийлгэх боломжтой эсэхийг үнэлэх шаардлагатай. Бусад оронд үндсэн эмчилгээ нь өдрийн эмчилгээ байдаг бөгөөд үйлчлүүлэгчээ эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагатай үед өдрийн эмчилгээнээс татгалзаж байгаа тухай маягт бөглөдөг. Өдрийн эмчилгээг сонгохдоо өвчний төрөл, эмчилгээний хэлбэр өдрийн эмчилгээнд тохирохоос гадна үйлчлүүлэгчийн биеийн ерөнхий байдал, хавсарсан өвчин болон бусад эрсдэлт хүчин зүйлс эмчилгээний үр дүнд нөлөөлөх эсэхийг харгалзан үзнэ. Цаашид тодорхой хугацааны дараа эмч болон техникч сургаж бэлтгээд өвдөлт намдаах эмчилгээний технологи нэвтрүүлэхийг зорилгоо болгох нь зүйтэй. Тухайлбал, нурууны хүчтэй өвдөлтийг эмчилж болох юм.

Үйл ажиллагааны төсөөлөл: Өдрийн эмчилгээ нь ажлын өдрүүдэд 8-18 цагийн хооронд явагдана.

2.5.3 Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ

Үүрэг, үйл ажиллагаа: Хэвтүүлэн эмчлэх хэсэг нь хүнд өвчин болон эмчилгээний эрсдлийн улмаас 24 цагийн хяналт шаардлагатай өвчтөнийг хэвтүүлэн эмчилдэг. Хэвтүүлэн эмчлэх хэсэгт өвчтөнүүдийг тухайн төвийн амбулатори болон яаралтай тусламжийн хэсгээс илгээдэг. Тиймээс сонгогдсон болон яаралтай өвчтөнүүдийг хэвтүүлэн эмчилнэ. Тасгуудыг дараах байдлаар ангилна:

- Хүүхдийн тасаг – хүүхдүүдийг наснаас нь хамааран 2 ангилалд хуваан хэвтүүлнэ: Нялхас (0-5 нас) хүүхэд (5-12 нас)
- Насанд хүрэгчдийн тасаг – Насанд хүрсэн өвчтөн хүлээн авна. Эмэгтэй 2 ортой, эрэгтэй 2 ортой өрөөнүүдтэй байна. Үндсэн мэргэжлийн тусламж үзүүлнэ. Өвчтнүүдийн дараалал үүсэхээс сэргийлж орыг илүү үр дүнтэй ашиглах боломжтой.

Хүний нөөцийн бодлого ба Стратегийн асуудлууд: Тасгуудын өвчтнүүдийг амбулаторийн үзлэгийн эмч нар тойролт хийн эмчилнэ. 24 цагийн турш нэг эмч хэвтүүлэн эмчлэх хэсэгт ажиллана.

Тасгийн сувилагч нар уламжлалт үйл ажиллагааны арга барилаас илүү орчин үеийн багаар ажиллах арга барилд шилжинэ. Туслах сувилагч нар сувилагч нарын ажилд тусална. Өвчтнүүдийн ар гэрийнхнийг өөрсдөө зөвшөөрсөн нөхцөлд зарим төрлийн асаргаа хийхийг хүсч болно (хооллох, усанд оруулах, хөдөлгөөн хийлгэх г.м).

Үйл ажиллагааны төсөөлөл: Тасгууд 7 хоногийн турш 24 цагаар ажиллах шаардлагатай. Эх барихаас бусад хэсгийн хувьд шөнийн ээлжинд ажлын ачаалал багасдаг, амралтын өдрүүдэд өвчтнүүд эмнэлгээс гарч өвчтний тоо цөөрдөг зэрэг ажлын ачааллыг таамаглах боломжтой.

2.5.4 Лаборатори

Үүрэг, үйл ажиллагаа: Энд тухайн төийн амбулатори, хэвтүүлэн эмчлэх хэсэг, нэгжүүдийн өвчтний шинжилгээний дээжүүд ирнэ. Хагас автомат анализатороор хийгдэх шинжилгээнүүд:

- Шээсний ерөнхий шинжилгээ
- Цусны ерөнхий шинжилгээ
- Биохимийн шинжилгээ

Түргэвчилсэн оношлуураар хийгдэх шинжилгээнүүд:

- Жирэмсэн тодорхойлох өндөр мэдрэг сорил
- Цусны серологи (тэмбүү)
- Иммунологийн шинжилгээ (Гепатит С, Гепатит В, ХДХВ, Н.пилори)

Микроскопын тусламжтайгаар хийгдэх шинжилгээнүүд:

- Эмэгтэйчүүдийн сорил PAP сорил
- Үтрээ ба шээсний сүвний сорьц шинжлэх
- Өтгөний шинжилгээ.

Шинжилгээг хийхдээ эмнэлгийн мэдээллийн системийг ашиглан алдаа гарахаас сэргийлж, шинжилгээний дүгнэлтийг шуурхай гаргах системийг ашиглана.

Хүний нөөцийн бодлого: Лаборатори бүрийг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн хариуцан ажиллана. Мөн лабораторийн лаборант, тэдгээрт туслах эмнэлгийн мэргэжилтэн ажиллана.

Стратегийн асуудлууд: Загвар сум, өрхийн эрүүл мэндийн төвд лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллана.

Үйл ажиллагааны төсөөлөл: Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн лаборатори нь 8:30-18:30 цагийн хооронд ажиллана. Яаралтай шинжилгээг шөнө хийх боломжтой байна.

2.6 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг даатгалын сангаас санхүүжүүлэх хүрээнд магадлан итгэмжлэгдсэн, сонгон шалгаруулалтанд тэнцсэн өрх, сум, тосгоны ЭМТ-ийн 4 төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

2022 оны ЭМДҮЗ-н 5-р тогтоолоор өмнөх 03-р тогтоолын Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журамыг шинэчлэн баталсан. Энэхүү тогтоолын хүрээнд сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх дээрхи (яаралтай, түргэн, хэвтүүлэн эмчлэх) тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаас санхүүжүүлэхээр болсон. Дээрхи тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцох санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлж, төлбөрийн аргыг шинэчлэн баталсан.

Эрүүл мэндийн багц хуулиудын нэмэлт өөрчлөлтийн хүрээнд улсын төсөв, ЭМД-ын сангуудыг нэгтгэж ЭМД-ын санд төвлөрүүлэх, тусламж, үйлчилгээний чанартай уялдсан стратегийн худалдан авалтын хүрээнд ЭМДЕГ нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай “Тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ” байгуулах болж байна. Энэхүү гэрээгээр тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээ, тусламж үйлчилгээний тоо болон чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд болон талуудын харилцах сувгийг тодорхойлсон. Гэрээгээр Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80 хувийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгон, үлдэгдэл 20 хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн сар бүр цахимаар гэрээний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн олгох эсэхийг шийдэхээр заалт орсон. Энэхүү гэрээний хавсралтаар гарцад суурилсан 14 гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт батлагдсан.

Өнөөгийн Санхүүжилтийн тогтолцоо нь илүү гүйцэтгэлд суурилж байгаа тул эхэлж орлогоо төлөвлөх, зардлаа оновчтой хуваарилах хэрэгцээ үүсч байна. Тогтмол зардлыг орон нутаг хариуцаж байгаа хэдий ч хэт том барилга нь орлогоос давсан зардлыг бий болгох эрсдэлтэйг анхаарах шаардлагатай. Харин ЭМДҮЗ-н 5-р тогтоолын хүрээнд зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилттой уялдуулан шинэ барилгын зураг төсвөө зохион байгуулах шаардлагатай.

3. СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа:

1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт (MNS 5081:2013) -аас “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн хүний нөөцийн доод хязгаар”-ын 1000 хүн амд 1 ерөнхий мэргэжлийн их эмч гэх мэт хүний нөөцийн стандартын тоо хэмжээг, “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн барилгын өрөө, тасалгааны талбай” гэсэн хэсгийн “Хэвтүүлэн эмчлэх өрөө нэг оронд 7-9 кв” гэх мэт өрөөнүүдийн хэмжээний стандартын заалтуудыг тус тус баримталсан,
2. Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яамны захиалгаар “Хот төлөвлөлт, судалгааны институт”-ын 2021 онд боловсруулсан “10 ортой нэг маягийн эмнэлгийн барилга”-ын ажлын зурагнаас “Тусгаарлах өрөө”, “Дархлаажуулалтын өрөө”, “Төрөх хэсэг” гэх мэт өрөөний байршил, урсгал, хэмжээг төлөвлөлтөнд ашигласан,
3. “Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийг бэлтгэх техник туслалцааны төслийн тайлан”-аас осол гэмтлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх өрөө, эрчимт эмчилгээний өрөө, үзлэгийн өрөөнүүдийг хуваалцах, эмнэлгийн хог хаягдлын зохион байгуулалт, цаг агаарын саад бэрхшээлийг шийдсэн хаалга бүхий үүдний танхим зэрэг шийдлүүдийн саналыг тусгасан,
4. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/52 тоот тушаалаар батлагдсан “Сум, тосгоны ЭМТ-д тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, тусламж үйлчилгээний

- жагсаалт"-ын дагуу СЭМТ-д үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний жагсаалтыг тодорхойлсон,
5. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт(MNS 5292:2017)-аас “Эмнэлгийн тусламж үйлчилгээ”, “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”, “Нэг өрхийн эмч, нэг өрхийн сувилагчид 1800-2000 үйлчлүүлэгч ногдохоор зохицуулна”, “Нэг үзлэг, зөвлөгөөнд 15 минутаас доошгүй хугацаа зарцуулдаг байна”, зориулалтын 15 өрөөний жагсаалт зэргийг төлөвлөлтөнд ашигласан,
 6. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/216 тушаалаар батлагдсан “ӨЭМТ-д тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, тусламж үйлчилгээний жагсаалт"-ын дагуу ӨЭМТ-д үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний жагсаалтыг тодорхойлсон,
 7. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл (ЭМДҮЗ)-ийн 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 1 ба 2 дугаар тогтоолуудаас эрүүл мэндийн анхан шатны сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ЭМД-ын сангаас санхүүжилт авах боломжтой тусламж, үйлчилгээг энэхүү төлөвлөгөөнд түлхүү оруулсан.
 8. Төсөл хэрэгжих сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сүүлийн 5 жилийн дундаж статистик үзүүлэлтүүдийг үндэслэн хүний нөөц, эмнэлгийн ор, үзлэгийн эмчийн хэрэгцээг тооцож гаргасан.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус төвөөс үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ (оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламж, захиргаа, эмнэлгийн логистик сүлжээ, засвар үйлчилгээ зэрэг) үйлчлүүлэгчдийн хамрах хүрээ, бусад хэсгүүдтэй харьцах уялдаа холбоог тодорхойлсон. Мөн хэсэг, нэгж тус бүрийн үйл ажиллагааны бодлого ба өөр хоорондоо хэрхэн харилцан уялдаатай ажиллах талаар тусгасан. Дараах хүснэгтэнд эмнэлгийн үйл ажиллагааны үндсэн нэгжүүд болон тэдгээрийн хүчин чадлыг тодорхойлсон болно.

3.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын үйл ажиллагааны төлөвлөгөө

Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын эхэлж энэ онд барьж эхлүүлэх талаар ТХН-ээс мэдэгдсэний дагуу төлөвлөлтийг танилцуулж байна. Улаанбаатар хотын барилга барих 3 өрхийн эрүүл мэндийн төвүүд нв хүн амын тооноос өөр ялгарах зүйлгүй,

адилхан тусламж үйлчилгээ үзүүлдэг тул, зөвлөх багаас нэг маягийн загвараар барилга барих саналыг дэвшүүлж байна.

Загвар өрхийн эрүүл мэндийн төвийн байрны өрөө тасалгаануудын талбайн хэмжээ, тухайн өрөөнд тавигдах шаардлага, байрлах тоног төхөөрөмж, тавилга зэрэг хүчин чадлыг дараах хүснэгт(**Хүснэгт-5**)-ээр харуулж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг маягийн загварын барилгын нэгдүгээр давхрын өрөөнүүдийн байршил, хэмжээг (**зураг-1**), нэгдүгээр давхрын өрөөнүүдийн байршил, хэмжээг (**зураг-2**) тус тус танилцуулж байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам, шалгуур үзүүлэлт, жагсаалт батлах тухай” А/540 тоот тушаалаар сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг хавсралтаар баталсан байна.

Энэхүү тушаалаар “А” зэрэглэлд өөрийн сумын иргэдэд өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс гадна зэргэлдээх сумын хүн амд 4-өөс доошгүй үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадавхи бүхий сумын эрүүл мэндийн төвд Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төв, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвүүд, “Б” зэрэглэлд улсын хилийн дагуу болон улсын чанартай автозам, төмөр замын дагуу байрласан, осол гэмтлийн онцгой бүс, уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн бүс нутгийн сумын эрүүл мэндийн төвд Булган аймгийн Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв, “А” болон “Б” зэрэглэлээс бусад “В” зэрэглэлд Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төв тус тус орж байна.

Хүснэгт 5. Загвар ӨЭМТ-ийн барилгын өрөө, тасалгааны талбайн хэмжээ, хүчин чадал


3.1.1. Загвар өрхийн эрүүл мэндийн төв

| Өрөөнүүдийн нэрс | | Өрөө - ний тоо | Нэг ж М.к в | Нийт талба й М.кв | Хүчин чадал |
|--|--------------------------|-------------------------|----------------------|-------------------------|---|
| <i>Нэгдүгээр давхар</i> | | | | | |
| Үйлчлүүлэгчийн хувцасны өлгүүр | | 1 | 3 | 3 | Гол хаалгаар ороход тэргэнцэртэй хүн орох налуу замтай байна.20-30 хүний хувцасны өлгүүр, хөтөч, бүртгэлийн ширээтэй, вестибюльд 12 сандалтай, сурталчилгааны телевизтэй, самбарууд байрлуулна. Хананд унахаас сэргийлэх бариулууд байрлуулна. |
| Хүлээлгийн хэсэг (вестибюльд 12 сандалтай) | | 0 | 12 | 12 | |
| Хөтөчийн хэсэг (вестибюльд) | | 0 | 4 | 4 | |
| Яаралтай тусламжийн өрөө, тарианы өрөө | | 1 | 12 | 12 | Цоожтой эмийн шүүгээ, хөргөгч, үзлэгийн ор, тэргэнцэр, яаралтай тусламжийн иж бүрдлийн шүүгээ, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, отсос, өвчтөний хяналтын мониторотой байна. |
| Эмчийн үзлэгийн өрөө | | 6 | 12 | 72 | Үзлэгийн ор, ширээ, сандал, компьютер, хэвлэгч, номын шүүгээ, үзлэгийн эмч зүрхний цахилгаан бичлэг хийнэ. |
| Лабораторийн хэсэг | Шинжилгээ хүлээж авах | 1 | 4 | 4 | Цус авах болон шинжилгээний өрөөнд зориулсан сандал, ширээ, лабораторийн зориулалттай ширээ, хөргөгч, тог баригч, цус, шээсний ерөнхий, биохимийн шинжилгээ хийх хагас автомат анализатор, түргэвчилсэн оношилгоо, микроскопийн шинжилгээ хийх боломжтой байна. |
| | Шинжилгээ хийх | 1 | 3 | 3 | |
| | Лаборантын өрөө | 1 | 4 | 4 | |
| | Шинжилгээний хариу олгох | 1 | 2 | 2 | |
| Тусгаарлах хэсэг | Тусгаарлах өрөө | 1 | 9 | 9 | Тусгаарлах өрөө нь дотроо ариун цэврийн өрөөтэй, гадагш шууд гарах хаалгатай байна. Ор, шүүгээ, сандал, мэдрэгчтэй угаалтууртай байна. Шар бүсэд хувцсаа сольж улаан бүсэд ороод дахин шар бүсэд хувцсаа сольж ногоон бүсэд орно. |
| | Шар бүс | 1 | 2 | 2 | |
| | Ногоон бүс | 1 | 2 | 2 | |
| | Ариун цэврийн өрөө | 1 | 3 | 3 | |


| | | | | | |
|---|----------------------------|---|----|----|--|
| Аюултай, энгийн хог хаягдлын хэсэг | | 0 | 6 | 6 | Шатны доор байрлуулж, гадагшаа шүүд хогоо гаргах хаалгатай байна. |
